

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН
ХОРООНЫ 2015 ОНЫ АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2016.04.25

Иргэний хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбоотой өргөн асуудлуудыг шийдвэрлэхэд санал оруулах, хөдөлмөрлөх явцад ажлын орчин нөхцлийг дээшлүүлэх, нийгмийн асуудлаа (цалин хөлс нэмэгдүүлэх, тэтгэмж дэмжлэг үзүүлэх бусад) шийдвэрлэхэд нь ажил олгогч болон холбогдох газруудад уламжлах, шийдвэрлүүлэхэд гол зорилтоо болгосон иргэдийн дуу хоолойг бодлого боловсруулагчид, ажил олгогчид хүргэж байдаг ажилдын эрх ашгийг хамгаалсан төрийн бус байгууллага нь салбар бүрийн Үйлдвэрчний эвлэлийн хороод байдаг.

Энэ ч утгаараа салбаруудын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоодууд нэгдэж иргэн та бүхний эрхийг хамгаалан цалин хөлс нэмэгдүүлэх, хуулиудад нэмэлт өөрчлөлтийг оруулах, нийгмийн асуудлаа шийдвэрлүүлэх талаар тэмцэж үр дүнд хүрч байсан нь олонтой.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Үйлдвэрчний эвлэлийн салбар хорооны бүрэлдэхүүн Засаг даргын Тамгын газрын ажилчдын дотоодын хуралдаанаар шинэчлэгдэн олонхийн саналаар тэргүүлэгчдээ шинээр томилон 2013 оны 09 сард албан ёсоор тамга тэмдэгээ хүлээн авч авч үйл ажиллагаагаа эхлүүлсэн болно.

Тэргүүлэгчид нь ажил олгогчтой ажилтнуудын эрхийг хамгаалах талаар гэрээ байгуулах зорилгоор ажилчид нэг бүрт тусгай саналын хуудас боловсруулан хүргүүлж ажил зохион байгуулж нийт 45 саналын хуудас тараагдсанаас 18 хүн саналаа ирүүлсэнийг судалж үзэхэд ажилчдын цалин нэмэгдүүлэх, мэргэжлийн сургалтанд хамруулах, ажилчдын чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэхэд анхаарах, ажил мэргэжлийн чиглэлээр туршлага судлах арга хэмжээг зохион байгуулах, хөдөлмөрлөх орчин нөхцлийг сайжруулахад анхаарах асуудлуудыг гэрээнд тусгаж, гэрээг эцсийн байдлаар боловсруулж ажил олгогч х аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад танилцуулан Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хамтын гэрээг шинээр байгуулан баталгаажуулан 2 жил гаруй хугацаатай ажиллаж байна.

Аймгийн засаг даргын Үйлдвэрчний хороо нь ажиллах хугацаандаа ажилчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор тодорхой санал санаачлагуудыг аймгийн Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо болон холбогдох дээд шатны байгууллагад хүргүүллээ. Тухайлбал. Салбар харгалзахгүйгээр цалинг индексжүүлэх, инфляцийн түвшинтэй уялдуулж цалинг нэмэгдүүлэх, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажилд зуучлагчдыг хөдөлмөрийн харилцааны заалтад оруулах, адил хөдөлмөрт адил цалин олгох, ээлжийн амралтыг ажлын 20 хоног болгож, нэмэгдэл амралтын өдрийг нэмэгдүүлэх, эх хүүхдээ 3 нас хүртэл нь харах хугацаанд эхчүүдийг тодорхой орлоготой байлгах, тэтгэврийн насыг нэмэхгүй байх, хүүхдийн хөдөлмөрийг үнэлэмжтэй болгох (уралдаанч хүүхдүүд) зэрэг асуудлуудаар санал боловсруулж хүргүүллээ.

Мөн Тамгын газрын ажилчдаас бичгээр ирүүлсэн сантехникийн болон хөдөлмөр хамгааллын хувцасаар хангах асуудлыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 122 тоот тушаалын дагуу шийдвэрлэх талаар холбогдох удирдлагад уламжлан шийдвэрлүүлж ажилчдын амаар болон бичгээр ирүүлсэн 7 саналыг хүлээн авч удирдлагад танилцуулан шаардлагатай асуудлуудыг Үйлдвэрчний эвлэлийн хорооны тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн шийдвэрлэж ажиллаж ирлээ.

Тухайлбал тус онд ажилчдын идэвхитэй амралт зохион байгуулах, хөдөлгөөнийг эрхэмлэн нийтийн биеийн тамирыг сурталчлах, ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, байгууллага хамт олны дотроос эрүүл мэндийн эмчилгээ хийлгэхээр явсан хүмүүст дэмжлэг үзүүлэх, байгууллагын нэрийн өмнөөс уралдаан тэмцээнд оролцож буй баг тамирчдад туслах, бүх нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд тодорхой санхүүжилтийг олгож хамт олны чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, эрүүл мэндийг хамгаалж урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлж ажиллаа.

2015 онд аймгийн Засаг даргын Үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн татвараас нийт 5721 457 мянган төгрөг (таван сая долоон зуун хорин нэгэн мянга дөрвөн зуун тавин долоон)-ийн орлого оржээ..

Хүснэгт 1. 2015 оны гишүүдийн татварын орлогын дүн

Он сар өдөр	Орлогын нэр	Орлогын хэмжээ (мян төг)
2015.02.27	Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн 1-2 дугаар сарын татвар	768 379.00
2015.03.02	Нийтлэг үйлчилгээний албаны үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн 1-2 дугаар сарын татвар	392 749.00
2015.03.20	Нийтлэг үйлчилгээний албаны үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн 3 дугаар сарын татвар	188 031.00
2015.03.24	Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн 3 дугаар сарын татвар	356 028.00
2015.04.22	Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн 4 дүгээр сарын татвар	377 222.00
	Нийтлэг үйлчилгээний албаны үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн 4 дүгээр сарын татвар	196 602.00
2015.05.22	Нийтлэг үйлчилгээний албаны үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн 5 дугаар сарын татвар	195 755.00
2015.05.27	Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн 5 дугаар сарын татвар	378 621.00
2015..06.05	Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн 5 дугаар сарын татварын дутуу төлөлт	384 160.00
2015.06.23	Нийтлэг үйлчилгээний албаны үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн 6 дугаар сарын татвар	192 243.00
2015.06.27	Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн 6 дугаар сарын татвар	360 647.00
2015.09.25	Нийтлэг үйлчилгээний албаны үйлдвэрчний	164 375.00

	эвлэлийн гишүүдийн 9 дүгээр сарын татвар	
2015.09.30	Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн 9 дүгээр сарын татвар	330 772.00
2015.10.23	Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн 10 дугаар сарын татвар	297 012.00
	Нийтлэг үйлчилгээний албаны үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн 10 дугаар сарын татвар	168 540.00
2015.12.01	Нийтлэг үйлчилгээний албаны үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн 11 дүгээр сарын татвар	170 047.00
2015.12.02	Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн 11 дүгээр сарын татвар	355 353.00
2015.12.23	Нийтлэг үйлчилгээний албаны үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн 12 дугаар сарын татвар	104 040.00
2015.12.24	Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн 12 дугаар сарын татвар	338 981.00
ДҮН (Таван сая долоон зуун хорин нэгэн мянга дөрвөн зуун тавин долоон төгрөг)		5 721 457

Зохион байгуулсан дээрх арга хэмжээг хувилж үзэхэд 2015 оны гишүүдийн татварын орлогын 856.6 мянган буюу 14.9 хувийг аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны татварт, 3027.0 мянга буюу 52.9 хувийг байгууллага хамт олны нийтийг хамарсан арга хэмжээнд, 630.0 мянга буюу 11 хувийг ажилчдын уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлэх, 550.0 мянга буюу 9.6 хувийг Эрүүл мэндийн үзлэг хийх, дэмжлэг үзүүлэхэд, 430.0 мянга буюу 7.5 хувийг тэргүүний гишүүдийг урамшуулахад, тус тус зарцуулсан байна.


2015 оны аймгийн ЗДТГ-ын ҮЭХ-ны гишүүдийн татварын орлогын зарцуулалтыг дэлгэрэнгүйгээр танилцуулахад:

Хүснэгт 2. 2015 оны гишүүдийн татварын орлогын зарцуулалтын дүн

Он сар өдөр	Татварын зарлага	Зориулалт
2015 оны үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн татварын орлого 2015 оны байдлаар нийт 5721.4 (таван сая долоон зуун хорин нэгэн сая дөрвөн зуун) төгрөг хуримтлагдсан аас зарцуулалтыг тооцоход:		
2015.03.02	300.0	Дарьгерхан, Батжаргал нарын эмчилгээний зардалд дэмжлэг
2015.03.24	1.202.0	Хэлтсүүдийн дунд “Эрүүл амьдрал, эрчимтэй хөдөлмөр” арга хэмжээ /Цэргийн 0123 дугаар анги дээр/
2015.05.22	825.0	Идэвхитэй хөдөлгөөн-Эрүүл мэнд арга хэмжээ /Шүүтийн тохой/
2015.06.02	856.6	Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн хороонд татварын 30 хувь
2015.08.06	260.0	Спортын уралдаан тэмцээн (Албан байгууллагуудын хоорондох волейболын аварга шалгаруулах тэмцээн эрэгтэй эмэгтэй багууд бооцоо, бусад)
2015.09.08	250.0	Ажилчдын Эрүүл мэндийн үзлэгт орсны төлбөрийг

		нөхөн шилжүүлэв
2015.10.27	170.0	Аймгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцсон ЗДТГ-ын багуудад бооцооны зардал
2015.11.13	200.0	ХААН банкны нэрэмжит аймгийн аварга шалгаруулах тэмцээнд ЗДТГ-ын эмэгтэй багуудын хувцас, бооцооны зардал
2015.12.23	430.0	Байгууллагын үйлдвэрчний эвлэлийн тэргүүний ажилчдыг шагнаж урамшуулах зардал (4 хүний шагнал урамшуулал, өргөмжлөл)
2015.12.23	1000.0	Байгууллагын шинэ жилийн арга хэмжээ
Нийт дүн	5 683.6	(Таван сая зургаан зуун наян гурван мянга зургаан зуун төгрөг)
Үлдэгдэл	37 857.0	(Гучин долоон мянга найман зуун тавин долоон төгрөг)

Хүснэгт 3.Зарцуулалтын төрөл, зүйл



2015 оны 03 сарын 24-ний өдрийн Хэлтсүүдийн хоорондох “Эрүүл амьдрал-эрчимтэй хөдөлмөр” хэлтсүүдийн хоорондох спортын арга хэмжээг 0123-р ангийн Спорт урлагийн цогцолбор дээр зохион байгуулж байгууллага хоорондын хамтын ажиллагааг сурталчлан таниулах, туршлага судлах хэлбэрээр зохион байгууллаа. Зураг 1.



Тэмцээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс хоорондын нийт 6 баг ур чадвараа спортын 5 төрлөөр оролцсоноос Нийгмийн хөгжлийн хэлтэс, Цэргийн штабын баг тэргүүлж шилжин явах цом гардлаа.

2015 оны 05 дугаар сарын 22-ний өдөр зохион байгуулагдсан Идэвхитэй хөдөлгөөн-Эрүүл мэнд арга хэмжээг Шүүгийн тохойд ЗДТГ-ын төрийн захиргаа удирдлагын хэлтэстэй хамтран зохион байгууллаа.

Зураг 2.



2015 оны эхний улиралд аймгийн Засаг даргын Тамгын газрын Үйлдвэрчний Эвлэлийн хорооноос санаачлан ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах арга хэмжээг зохион байгуулж 75 ажилчдаас нийт 67 буюу 89 хувь нь хамрагдаж хуулийн дагуу урьдчилан сэргийлэх үзлэгийн зардал 250.0 мянган төгрөгийг хорооноос шийдвэрлэв.



2015 оны шинэ жилийн арга хэмжээг 12 дугаар сарын 23-ны өдөр байгууллага хамт олноороо тэмдэглэн өнгөрүүлж уг арга хэмжээний зардалд 1000.0 төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Үйлдвэрчний эвлэлийн хорооноос гаргаж дэмжлэг үзүүлээ.



Үйлдвэрчний эвлэлийн тэргүүний гишүүн Э.Янжмаа



Үйлдвэрчний эвлэлийн тэргүүний гишүүн Д.Сэсээр



Үйлдвэрчний эвлэлийн тэргүүний
гишүүн Э.Насанхишиг



Үйлдвэрчний эвлэлийн тэргүүний
гишүүн Б.Энхбаатар

Цаашид байгууллагын Үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн татварын мөнгийг эрүүл мэндийн болон нийтийн биеийн тамирын арга хэмжээ, ажилчдын эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх, ажилчдаас хөдөлмөрийн маргаантай холбоотой асуудлаар өмгөөлөгч хөлслөх, хамт олныг идэвхижүүлж, мэдээлэл сургалт сурталчилгаагаар хангахад илүүтэй зарцуулж байх нь зүйтэй гэж үзэж байна.

ТАЙЛАН БИЧСЭН

С.ДОРЖ